

Монгол, хятад хэлний хэмжүүр үгийн харьцуулсан судалгаа

МИНА*

*Монгол Улс, Улаанбаатар, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм,
хүмүүнлэгийн ухааны сургууль*

Гөрөөчингийн ЦОГЗОЛМАА

*Монгол Улс, Улаанбаатар, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн
Гадаад харилцааны алба*

Received: May 15, 2025 | **Accepted:** September 29, 2025 | **Published:** October 15, 2025

Хураангуй: Монгол хэл нь гарал үүслийн хувьд алтай язгуурын, залгамал бүтцэт хэл юм. Хятад хэл нь Хятад, Төвд язгуур хэлний бүлгээс үүсэлтэй бөгөөд тусгаарлагч буюу изолятив бүтэцтэй хэл юм. Хоёр хэл бичиг үсгийн хувьд харилцан ялгаатай байдаг. Монгол хэлний хувьд авианы бичиг үсгийг хэрэглэдэг бол хятад хэл нь утгын бичиг үсэг хэрэглэдгээрээ ялгаатай байдаг.

Монгол, хятад хэл хоёулаа тодорхой тооны хэмжүүр үгтэй байдаг. Хоёр хэлний хэмжүүр үгийн илэрхийлэх арга, бүтцийн тодорхой ялгаатай байдлаас шалтгаалан монгол оюутнууд хятад хэлний хэмжүүр үгийг эзэмшихэд тодорхой хүндрэлтэй юм. Энэ өгүүлэлд монгол, хятад хэлний хэмжүүр үгийн илэрхийлэх арга, онцгойлон биед суурилсан танин мэдэхүй (*embodied cognition*) бүтцийн шинжийг харьцуулсан, хоёр хэлний хэмжүүр үгийн ижил төстэй болон ялгаатай талуудыг тодруулах нь монгол, хятад хэлний хэмжүүр үгийг ойлгож, эзэмшихэд хялбар болох үүднээс тус судалгааг хийв.

Түлхүүр үг: Монгол хэл, хятад хэл, хэмжүүр үг, биед суурилсан танин мэдэхүй

* Corresponding author, © Authors, 2025

Email: minamongol101@gmail.com  <https://orcid.org/0009-0009-2097-2716>



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

A Comparative Study of Measure Words (Classifiers) in Mongolian and Chinese

MINA*

School of Humanity and Social Sciences, Mongolian National
University of Education, Ulaanbaatar, Mongolia

TSOGZOLMAA Guruuchin

International Relations, Mongolian National University of Education
Ulaanbaatar, Mongolia

Abstract: Mongolian is an Altaic language with a predominantly agglutinative structure, while Chinese is derived from the Sino-Tibetan family and is a primarily isolating language. The two languages differ in terms of literacy: Mongolian employs phonetic literacy, whereas Chinese relies on semantic literacy.

Both Mongolian and Chinese have specific measure words. However, because the two languages differ in how these measure words are expressed and structured, Mongolian students often face challenges when learning Chinese measure words. This paper examines the methods of expression, focusing on the embodied cognitive structures of measure words in both Mongolian and Chinese. Identifying the similarities and differences between the two languages can help promote a clearer understanding and more effective acquisition of measure words.

Keywords: Mongolian language, Chinese language, measure words, embodied cognition

1. Удиртгал

Хэмжүүр үг нь хэмжих нэгжийг илэрхийлдэг. Зэрэгцүүлэн судалж буй монгол, хятад хоёр хэл өөр өөр хэв шинжийн тул ангилал, илэрхийлэх арга, бүтцэд нийтлэг болон зарим ялгаатай талууд байдаг. Монгол, хятад хэлний хэмжүүр үгийн харьцуулсан судалгаа нь хоёр хэлийг сурах, судлах, заах арга зүйн ач холбогдолтой.

“Хятад хэлний хэмжүүр үгийн хөгжлийн үүднээс авч үзвэл Иний 殷 (Шан улсын сүүлч үе) гүрний үед жин, хэмжүүр, сав, мөнгөн тэмдэгтийн хэмжүүр үгс байдаг. Цинь гүрний өмнөх үед ‘匹хуй/толгой, 两хоёул, 张ширхэг, 个ширхэг’ зэрэг бодгаль биеийн хэмжүүр үгс гарч ирсэн бөгөөд Тан, Сүн гүрний дараа олон тооны хэмжүүр үгс гарч ирсэн нь үндсэндээ орчин үеийн хятад хэлний хэрэглээтэй төстэй байв. Орчин үед хятад хэлний хэмжүүр үгийн тоо тав, зургаан зуу болж хөгжсөн байдлыг хятад хэлний хэмжүүр үгийн хувьслын үүднээс авч үзвэл, ясан бичээсэнд (甲骨文) ердөө 10 гаруй, алтан бичээсэнд 40 гаруй, Хан,

Вэй, зургаан гүрний үед 200 гаруй, орчин үеийн хятад хэлэнд 500-600 хэмжүүр үг байдаг.” (孙汝建, 2003:292) Профессор Хэ Жиэгийн тоон бүртгэлээр “Хятад хэлэнд 789 орчим хэмжүүр үг байдаг.” (何杰, 2008:28) хэмээн тэмдэглэжээ. Хятад-Төвд хэлний бүлийн хятад хэл язгуур хэл бөгөөд хэмжүүр үгээр нэн баялаг, үгсийн аймгаар харьцангуй идэвхтэй байдаг, өргөн хүрээний хэрэглээтэй, ихэнх нь нэр үгнээс гаралтай юм.

Монгол уран зохиолд хамгийн эртний хэмжүүр үг ашигласан нь 1225 онд бичигдсэн “Чингисийн чулуун бичээс”-д барууны эрхшээлийн дараа болсон их хуралдай, хурлын хэлэлцэх асуудалд байт харвааны алсын зайн харвааны тэмцээнд Есүнгөөгийн анхны харвалтын зай 335 алд хол харваж, аварга болжээ. Энэхүү бичээсэнд дурдсан “335 алд” гэдэг “алд” нь монгол уран зохиолд гарсан хамгийн эртний хэмжүүр үг юм. “Монголын нууц товчоон”-д “程зам, 步алхам, 度хэм” зэрэг уртын хэмжүүр үгс болон, “盞аяга, хундага (эртний монголчуудын сүүтэй цай, саалийн архинд хэрэглэдэг сав), 桶хөнөг, суулга, хувин, торх” болон “丛цуврал, бөөм, 处газар, бууц, 群бүлэг, сүрэг”, “年Жил, 宿 хоног, 日өдөр, 夜шөнө” гэх мэт багтаамж буюу хүндийн хэмжүүр, хүрээ царын хэмжүүр, цаг хугацааны хэмжүүр үг олон илэрсэн нь монгол хэлний хэмжүүр үгийн хэрэглээг батлах чухал баримт болов. Тухайлбал, “Монголын нууц товчоон”-д “Бат, хипчак нутгаас Егэдэй хаанд нууцаар ечиж илгээсэн нь: ‘... Энэ хурим дээр би бvх хан хевvдийн ахмад тул нэг хоёр аяга сархад тэргvвлэн уув.’ ” гэдэгт “хоёр аяга сархад” (两盞酒) гэж архийг “аяга” буюу “盞”-гаар хэмждэг байжээ. “Монголын нууц товчоон” зэрэг чухал баримт бичгүүдийг судлахад монгол хэлэнд хэмжүүр үг цөөн байдаг нь ажиглагддаг. Гэвч хэлний хэрэглээний явцад олон нэр үг, үйл үгийг хэмжүүр үгийн үүрэгтэйгээр ашигладаг байна. Нийгэм хөгжихийн хэрээр монгол хэлний хэмжүүр үгийн хэрэглээний цар хүрээ улам бүр өргөжиж, тодорхой болох хандлагатай. Монгол хэлний дүрмийн мэдээллийн толь бичгийн хэмжүүр үгийн хөмрөг-т “нийт 144 хэмжүүр үг багтсан.” (Хай инхуа, Насан-урт, 2009: 71-72) хэмээн тэмдэглэжээ. Монгол хэлний хэмжүүр үг нь бодит үгийн ярианы томоохон хэсэгт хамаарахгүй. Үүний учир нь монгол хэлний хэмжүүр үгийн ихэнх нь нэр үг байдагт оршино. Тухайлбал: **Азарга** адуу, гурван **нүүдлийн** газар гэх мэт.

Монгол хэлний хэмжүүр үгийн чиглэлээр мэргэшсэн судлаачид цөөхөн, өнөөг хүртэл монголын хэл шинжлэлийн салбарт нэгдсэн ойлголттой болоогүй, судалгаа нь төлөвшөөгүй, хангалттай системтэй, иж бүрэн, гүнзгий судалгааны баримт бичиг, нэг сэдэвт бүтээл хангалттай бус байна. Олон жилийн сургалт судалгааны явцад нийгмийн хөгжил дэвшил, хэлний хөгжлийг дагаад монгол хэлний хэмжүүр үгийн хэрэглээ нь зөвхөн “Монголын нууц товчоон”-д төдийгүй бусад түүхэн сурвалж бичиг, уран зохиолоор баримт болгон гүнзгий судалгаа хийх хэрэгтэй байна. Орчин үеийн хэлний судалгаанд хэмжүүр үгийн судалгааг нэн түлхүү ахиулах нь монгол, хятад хэлний хэмжүүр үгийн зохистой хэрэглээг дэмжих ба хэлний хөгжилд зохих хэмжээний тус нэмэр үзүүлэх юм. Энэхүү өгүүлэл нь монгол, хятад хэлний хэмжүүр үгийн ангилал, илэрхийлэх

арга, бүтцийн шинжийг харьцуулахыг зорьж хоёр хэлний хэмжүүр үгийн илэрхийллийн арга, бүтцийн онцлогийг харьцуулснаар хэлний бүтцийн талаарх мэдлэгийг баяжуулж чадна. Хоёр хэлний хэмжүүр үгийн хөгжлийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, цаашдын судалгааны чиглэлийг тодорхойлоход хувь нэмэр оруулах юм.

2. Судалгааны арга зүй

Монгол, хятад хэлний хэмжүүр үгийн үүсэл хөгжил, тоо хэмжээ, хамрах хүрээ нь их ялгаатай учраас судалгааны үнэ цэнийг өндөр төвшинд хүргэсэн юм. Энэхүү судалгаанд дараах хоёр арга зүйг ашигласан, тухайлбал:

1. Харьцуулсан судалгаа: Монгол, хятад хэлний хэмжүүр үгийг харьцуулж, ижил төстэй болон ялгаатай шинж чанарыг олж тогтооно.
2. Харьцуулсан анализ: Хоёр хэлний хэмжүүр үгийн онцлог, бүтцийг нарийвчлан судалж, хэрхэн ялгаатай байдгийг тайлбарлана.

Ийнхүү монгол, хятад хэлний хэмжүүр үгийг харьцуулан судалснаар хэл шинжлэлийн онол, практикт ач холбогдол бүхий үр дүнд хүрч, цаашдын судалгааг гүнзгийрүүлэх суурь болно гэж үзэж байна.

3. Монгол, хятад хэлний хэмжүүр үгийн судалгааны байдал

3.1. Монгол хэлний хэмжүүр үгийн судалгааны өнөөгийн байдал

Монгол хэлний хэмжүүр үгийн судалгааны өнөөгийн байдлыг авч үзвэл, монгол хэл шинжлэлийн бүтээлд хэмжүүр үгийг ангилах, судлах талаар янз бүрийн оролдлого хийсээр ирсэн, хэмжүүр үгийг тусгайлан судалсан бүтээлд Д.Бадмаанямбуу (2004) “Монгол хэлний тоо хийгээд хэмжээ илэрхийлэх ёс, түүний зүй тогтол” байна.

Уламжлалт хэмжүүр үгийн талаар Г.Гонгоржав, А.Пүрэвжанцан, Б.Пүрэв-Очир, Ж.Бат-Ирээдүй нар судалжээ. (Shanjimituo, 2022: 7) Хэмжүүр үгийг ангилах талаар янз бүрийн оролдлогыг хийсээр ирсэн Ш.Лувсанвандан, М.Базаррагчаа, Ц.Өнөрбаян, Д.Отгонсүрэн, Б.Пүрэв-Очир нар хэмжүүр үгийг тоо, тооны нэр, жинхэнэ нэрийн алинд нь ч хамааруулалгүй, бие даасан үгийн аймаг гэж үзжээ. Тухайлбал:

Г.Гонгоржав (1992) “Монголчуудын эрдэм ухааны уламжлал” номдоо монголчууд аливаа хэмжил, түүний нарийвчлалд ихээхэн анхаарч “долоо хэмжиж нэг огтол” гэдэг зарчмыг баримталж иржээ.

А.Пүрэвжанцан (1998) “Монголчуудын хэмжээ илэрхийллийн товч тайлбар толь” номдоо “Монголчуудын хүнд, хөнгөн, их бага, урт богино, талбай эзлэхүүн, орон зай, хугацаа, ахуй байдал, байгаль цаг уурын” гэх мэт хэмжээ илэрхийлэх ойлголтууд нь физик, математик, хими, философи зэрэг бусад шинжлэх ухааны товч өгөгдөхүүнтэй дүйж байдаг.

Б.Пүрэв-Очир (2007) “Монгол хэлний бүтэц, утга, үүрэг, хэрэглээ” номдоо “Монгол ардын уламжлалт тоо зүй, хэмжил зүйн нэрс, тойм тооны утгат нэрд хамааруулан үзэж болмоор ерөнхийдөө баримжаа утгатай ижил үгийн олонлог байгаа, тоо хэмжээний үгсийн утгын оронд хамаарах өвөрмөц бүлэг үгс” гэсэн байна.

Ж.Бат-Ирээдүй (2010) “Монгол хэлний тооны болон хэмт үгийн сан” номдоо “Монгол хэлний хэмжээ заасан үг, хэмжээ илэрхийлэх үг, хэмжил зүйн нэрс” зэрэг тайлбарын олон янзаар нэрлэх үгийг товчлон хурааж хэмт үг хэмээн нэрлэв.

Өвөр монголын судлаачдын хэмжүүр үгийн тухай сэтгүүлийн нийтлэлд орсон судалгаагаас үзвэл: Л.Цэцэн-билиг “Монгол хэлний зээллэгийн хэмжүүр үгийн судалгаа” (1985)-даа монгол хэлний хэмжүүр үгсийг ихэвчлэн нэр үг, үйл үгсээс зээлж авсан гэж бичсэн байв. Насан-уртын “Монгол хэлний хэмжүүр үг, Монголчуудын хэмжих ёс заншил” (1991) өгүүлэлдээ монгол үндэстний өвөрмөц хэмжүүр үгийн талаар бичжээ. Ганжууржав “Хэмжүүр үгийг зөв ашиглах” (1996) өгүүлэлдээ бодит амьдрал дээр хэмжүүр үгийг буруугаар ашиглах асуудлын талаар бичжээ. Баатар “Монгол хэлний хэмжүүр үг” (1997) өгүүлэлдээ монгол хэлний хэмжүүр үгийг 20 төрөлд хуваажээ. Мэн.Гэрэл “Монгол хэлний хэмжүүр үгийн илэрхийлэх арга ба шинж чанар” (1998) өгүүлэлдээ монгол хэлний хэмжүүр үгийн илэрхийлэх арга нь тусгай хэмжүүр үг ашиглах ба хэмжүүр үг ашиглахгүй гэсэн хоёр нөхцөл байдлыг авч үзсэн байдаг. Соёл “Монгол хэлний хэмжүүр үгийн тухай” (1997) өгүүлэлдээ хэмжүүр үгийн төрөл, дүрмийн шинж чанар, чиг үүргийг бичжээ. Буян-Эрхэм (2015) “Монголын нууц товчооны хэмжүүр үгийн судалгаа”, “Монгол, хятад хэлний хэмжүүр үгийн харьцуулсан судалгаа”, “Монгол уран зохиол дах хэмжүүр үгийн хэрэглээ” зэрэг өгүүллийг хэвлүүлсэн байна.

3.2. Хятад хэлний хэмжүүр үгийн судалгааны өнөөгийн байдал

Хятад хэлний хэмжүүр үгийн судалгааны өнөөгийн байдал монгол хэлний хэмжүүр үгийн судалгаатай харьцуулахад хятад хэлний хэмжүүр үгийн судалгааны ажил нь эртнээс судлагдсан, судалгааны хүрээ өргөн, агуулга баялаг, судалгааны идэвхтэй ахиц дэвшилттэй байдаг. Хятад хэлний хэмжүүр үгийн судалгааны нэг сэдэвт бүтээлээс дурдвал: 刘世儒 (lǐ shì rú) “魏晋南北朝量词研究” буюу “Вэй, Жин, Өмнөд, Умард гүрний хэмжүүр үгийн судалгаа” (1965), 胡附 (hú fù) “数词和量词” буюу “тооны үг ба хэмжүүр үг” (1984), 郭先珍 (guō xiān zhēn) “现代汉语量词手册” буюу “орчин үеийн хятад хэлний хэмжүүр үгийн гарын авлага” (1987), “汉语量词的应用” “хятад хэлний хэмжүүр үгийн хэрэглээ” (1987), 刘学敏 (liú xué mǐn), 邓崇谟 (dìng chōng mǔ) нар “现代汉语名词量词搭配词典” буюу “орчин үеийн хятад нэр үг ба хэмжүүр үгийг хослуулах толь бичиг” (1989), 何杰 (hè jié) “现代汉语量词研究” буюу “орчин үеийн хятад хэлний хэмжүүр үгийн судалгаа” (2008), 宗守云 (zōng shǒu yún) “汉语量词的认知研究” буюу “хятад хэлний хэмжүүр үгийн танин мэдэхүйн судалгаа” (2012),

李明(lǐ mǐng) “现代汉语量词研究” буюу “орчин үеийн хятад хэлний хэмжүүр үгийн судалгаа” (2015), 刘伟(liú wěi) “汉语量词的习得与教学研究” буюу “хятад хэлний хэмжүүр үгийг эзэмших, боловсрох” (2019), 张华(zhāng huá) “汉语量词的历史演变与方言比较” буюу “хятад хэлний хэмжүүр үгийн түүхэн хувьсал ба аялгууны харьцуулалт” (2020), 陈静(chén jìng) “汉语数量词的语义与句法研究” буюу “хятад хэлний хэмжүүр үгийн утга зүй ба өгүүлбэр зүйн судалгаа” (2021), сүүлийн үед хэвлэгдсэн 惠红军(huì hóng jūn) “汉语数词的认知类型研究” буюу “хятад хэлний хэмжүүр үгийн танин мэдэхүйн судалгаа” (2024) бүтээлдээ танин мэдэхүйн хэл шинжлэлийн үүднээс хятад хэлний хэмжүүр үгийн танин мэдэхүйн механизм, өгүүлбэр дэх үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, туршилтын өгөгдөлд үндэслэн тоон үзүүлэлтүүдийн хэрэглээний дүрмийг авч үзсэн байна.

Эдгээр нэг сэдэвт бүтээл нь хятад хэлний хэмжүүр үгийн судалгааг олон талаас гүнзгийрүүлж, хятад хэлний хэмжүүр үгийг сонирхож буй судлаачдад тохиромжтой баримт, хэрэглэгдэхүүн хангаан өгсөн нь ирээдүйн замын чиглүүлсэнтэй адил юм. Үүний гадна 100 гаруй эрдмийн зэрэг горилсон бүтээл болон бусад судалгааны ажлын чиглэлээр бичигдсэн байна.

4. Монгол, хятад хэлний хэмжүүр үгийн илрэх арга, бүтцийн шинжийг харьцуулан судлах нь

4.1. Бодгаль биеийн хэмжүүр үгийн харьцуулалт

Биет нь салангид ба үл тасалдангийн хооронд ялгаатай байдаг. Тэдгээрийн дотроос салангид объектууд нь бие даасан хувь хүн бөгөөд түүний хэмжээг тоолох замаар олж авах боломжтой. Хятад хэлэнд тоо, нэр үгийг шууд нэгтгэх боломжгүй, ерөнхийдөө дунд нь хэмжүүр үгийг ашигладаг бөгөөд бүтэц нь “тооны үг + хэмжүүр үг + нэр үг” юм. Монгол хэлэнд тоо, нэр үгийг хослуулах хоёр нөхцөл байдал байдаг: нэг нөхцөл байдал нь монгол хэлэнд тоо, нэр үгийг хослуулахад дунд нь хэмжүүр үгийг ашигладаггүй, харин тоо, нэр үгийг шууд хослуулдаг бөгөөд түүний бүтэц нь “тооны үг + нэр үг” юм. Энэ үед энэ нь хятад хэлний илэрхийлэх аргаас зөрөөтэй юм. Тухайлбал:

Хятад хэл	Монгол хэл
五个人; 五位(тавуул)	- Таван хүн; Тавуул
三头牛(гурван толгой үхэр)	- Гурван үхэр
三匹马(гурван толгой адуу)	- Гурван адуу

Дээрх жишээгээс үзвэл, Монгол хэлэнд “хүн, үхэр, адуу” зэрэг нэр үгсийн тоо хэмжээг илэрхийлэхдээ тооны нэр үгийг өмнө нь байрлуулж, дунд нь хэмжүүр үг (жишээлбэл, “ширхэг”, “толгой” гэх мэт) заавал оруулах шаардлагагүй. Учир нь монголчууд юмыг тоолохдоо ерөнхий дүрс байдалд нь суурилан, нийтээр нь тоолдог онцлогтой. Жишээлбэл: “таван хүн”, “гурван адуу” гэх мэтээр шууд илэрхийлдэг. Мөн хүн, амьтны тоог илэрхийлэхдээ “ахмад+ууд”, “үхэр үүд”

гэх мэт нийлэг аргаар илэрхийлэх нь бий. Иймд монгол хэлний тоолох хэлбэр нь хятад, англи, орос зэрэг хэлнээс ялгаатай бөгөөд хэмжүүр үггүйгээр ч утгаа бүрэн илэрхийлэх боломжтой байдаг. Хятад хэлний “хүн, үхэр, адуу” зэргийн тоо хэмжээг илэрхийлэхдээ тооны нэр үгийг шууд нэр үгтэй хослуулах боломжгүй, дунд заавал нь “толгой” гэх мэтийн хэмжүүр үгийг оруулах шаардлагатай байдаг. Иймээс бодгаль биеийн хэмжүүр үгийн илэрхийлэх арга, бүтэц нь монгол, хятад хэлд ялгаатай байна. Адил тал нь заримдаа нэг төрлийн биет объектын бодгаль биеийн нэгж болон хамтын нэгжийг амархан андуурахаас болгоомжлон монгол хэлний бодгаль биеийн нэгжийн “тоо” гэсэн утгыг илүү тодорхой болгохын тулд нэр үгээр зарим “хэмжүүр”-ийн нэгжийг илэрхийлдэг. Түүний бүтэц нь “тооны үг + хэмжүүр үг + нэр үг” юм. Энэ үед монгол хэл нь хятад хэлтэй адил байдаг. Тухайлбал:

Монгол хэлний бодгаль биеийн нэгж Монгол хэлний хамтын нэгж

Нэг мөхлөг эрдэнэ шиш—一粒玉米 - Нэг түрүү эрдэнэ шиш—一棒玉米 (нэг шийдэм)

Нэг ширхэг тамхи—一支烟 - Нэг хайрцаг тамхи—一盒烟

Нэг хумс саримсаг—一牙蒜 (нэг шүд) - Нэг бүхэл саримсаг—一头蒜 (нэг толгой)

Нэг толгой чүдэнз—一根火柴 (нэг гожгор) - Нэг хайрцаг чүдэнз—一盒火柴

Хятад хэл нь тоо хэмжээг илэрхийлэхдээ заавал хэмжүүр үг ашигладаг онцлогтой. Нэр үгсийн шинж чанараас хамааран өөр өөр хэмжүүр үг хэрэглэдэг бөгөөд ихэнх тохиолдолд хэмжүүр үгийг орхигдуулж болдоггүй. Тухайлбал: “一本书” (нэг ширхэг ном), “一只羊” (нэг хонь), эдгээрийн дотроос “本” ба “只” хэмжүүр үгийг орхигдуулж болохгүй. Харин монгол хэлэнд бодгаль биеийн хэмжүүр үгийг бага хэрэглэдэг, ерөнхийдөө тоолж болох зүйлийн тоог төөрөгдөлгүйгээр нэр үгийн өмнө шууд **хэмжээ тогтоох тооны үгийг** (定量数词) хэрэглэдэг.

4.2. Хам бүтцэт хэмжүүр үгийн харьцуулалт

Монгол, хятад хэлний **хам бүтцэт хэмжүүр үг** (集合量词) буюу **урт, хүнд, багтаамжийн хэмжүүр үгийн** (度量衡量词) илэрхийлэх арга нь адилхан, бүр “хэмжүүр үг”-ийг хэрэглэдэг. Түүний дүрмийн бүтэц нь үндсэндээ ижил бөгөөд бүгд “тооны үг + хэмжүүр үг + нэр үг” хэлбэртэй байдаг.

Монгол, хятад хэлэнд “хэмжүүр”-ээр олныг заасан үед, нэр үгийн өмнө хам бүтцэт хэмжүүр үгийг ашигладаг. Тухайлбал:

Хятад хэл	Монгол хэл	Монгол хэл	Хятад хэл
一群羊	- Суурь хонь	Гурван нүүдлийн газар	- 三箭之地
一群马	- Азарга адуу	Долоон уулын цаана	- 十万八千里

Хятад хэлний жишээ дэх “群” (сүрэг) нь бодгаль биеийн үгээс ялгаатай, “тооны үг + хэмжүүр үг” гэх **тоо хэмжээний нэгж** (数量单位) болох юм. Нөгөө

нэг нь “箭” (сум) ба “里” (мил) хэмжүүрээр алс холын зайг илтгэдэг. Монгол хэлэнд юмны тоо хэмжээг үзэхэд “суурь”, “азарга”, “нүүдэл”, “уул” зэрэг төрлөөр нь ялгахыг урьдаар бодолхийлж байдгийг Б.Ринчен “... ямарваа нэг юмыг нэрээр нь заан нэрлэхдээ ганц ширхэг юм уу, олон юм уу гэж боддог ёсгүй ... цэцэг юм уу, мод юм уу, хүн юм уу, мал юм уу гэж юуны урьдаар төрлийг нь бид мэдэж авахыг урьдал болгодог ... цэцэг гэж төрлийг нь мэдэж авсан хойноо ямар цэцэг вэ? гэх зэргээр дараа, дараагаар нарийвчлах зүйл дэс дараагаар гарч ирэхээс биш, ав авсаар ганцхан ширхэг юм уу, нэг хэсэг юм уу, их олон юм уу гэдгийг урьдал болгохгүй ...” (Ринчен, 1969: 237) хэмээн дурджээ.

Монгол хүн тооны ганц юм уу, олон юм уу гэх харьцааг түрүүнд нь анхаарахгүй, эхлээд “төрөл” зүйл дээр нь анхаардаг. Үүнийг танин мэдэхүйн үүднээс Figure-Ground (дүрс-дэвсвэр), (图形-背景) гэж, монгол хэлэнд Figure гэдэг нь дүрс, Ground гэдэг нь дэвсвэр, хятад хэлэнд Figure гэдэг нь 图形 (дүрс), Ground гэдэг нь 背景 (дэвсвэр) болно. Ground (дэвсвэр) нь “төрөл”-тэй холбогдоно, Figure (дүрс) нь “Харьцаа, шинж”-тэй нь холбогдоно. Сэтгэл судлалын үүднээс хүн эхлээд юмыг харахдаа “дэвсвэр” (ерөнхий)-ийг нь анхаарахгүй, “дүрс” (тусгай) дээр нь анхаардаг. Жишээ нь, “Айлд нэг хар муур хар олбог дээр сууж байна” гэвэл, Европ хүн эсвэл хятад хүн эхлээд хар өнгөтэй ганц муур байхыг олж харахад, Монгол хүн бол юун дээр суугаа гэдгийг нь эхлээд анхаардаг. Хятад хүн эсвэл Европ хүн бол эхлээд “дүрс”-ийг нь анхаардаг. Харин, монгол хүний сэтгэхүй бол “ерөнхий” (Ground)-гөөс “тусгай” (Figure)-руу хандаж үздэг. Даруй, төрлийг нь мэдсэний сүүлээр дараа нь харьцаа руу шилждэг. Яг энэ ойлголт нь хэлэнд илрэхдээ эхлээд дүрсийн нэрийг хэлээд дараа нь дэвсвэрийн нэрийг хэлдэг. Жишээ нь, “Гэрийн хажууд нохой байна” гэдэгт “гэр” гэдэг нь дэвсвэр болж, “нохой” гэдэг нь дүрс болж байдаг. Иймээс нохойн хажууд гэр байна гэж хэлдэггүй, заавал эхлээд дэвсвэрийг нь хэлж, дараа нь сая дүрс болох жижиг юмыг нь хэлэх ёстой юм. Уул нь нохойн хажууд гэр байгаа нь зөв, гэхдээ хүний ойлголтын тогтолцоо, тархи ой ухаанд бол “ерөнхий юм нь тусгай юм аа багтаадаг” гэсэн ойлголт ялангуяа монгол хүний тархинд суучихсан учраас монгол хүн бол эхлээд том тоог дараа нь жижиг тоог, эхлээд цагыг дараа нь орныг, хамаг сүүлд нь шинж чанарыг нь хэлдэг нь ийм учир холбогдолтой юм. Тиймээс Б.Ринчений энэхүү санаа бол тухайн үед ч тэр, одоо ч гэсэн маш шинэлэг үзэл санаа байгаа нь илэрхий харагдаж байна.

“Хэмжүүр” нь үл тасалданги зүйлийг бодгаль биеэр тоолох боломжгүй үед монгол, хятад хэлний хэмжүүр үгийг илэрхийлэх арга нь адилхан байж, бүгд үл тасалданги зүйлийг илэрхийлдэг нэр үгийн өмнө хам бүтцэт хэмжүүр үгийг ашигладаг. Үүний нэг хэсэг нь урт, хүнд, багтаамжийн хэмжүүр үгийг ашигладаг, нэг хэсэг нь бусад үгсийн аймгаас (голчлон үйл үг ба нэр үгээр) дамжин хэмжээг илтгэдэг. Үүнийг биед суурилсан танин мэдэхүй (*embodied cognition*) жишээн дээр үзвэл,

Хүснэгт 1. Биед суурилсан танин мэдэхүйн (embodied cognition) хэмжих үйл

Биед суурилсан танин мэдэхүй (бага-их тийш)	Хятад хэл	Монгол хэл
Хуруу: чимх	捏 чимхэх (үйл үгээр хэлбэрждэг)	Нэг чимх давс
Ам: үмх; балга	一口水 нэг балга ус	Нэг балга ус (5-10 грамм) (Пүрэвжанцан, 1998: 6)
Гар: атга; тэвэр; Хувцас: өвөр; хормой	☐ 捏一把汗 хөлс асгарах (айсан сэтгэлийг дүрсэлсэн үг) ☐ 抱 тэврэх (үйл үгээр хэлбэрждэг) ☐ 怀抱 өвөр (нэр үгээр хэлбэрждэг)	☐ Атга чихэр ☐ Тэвэр өвс ☐ Өвөр чихэр ☐ Хормой мөс
Хөл: алцам	一步 нэг алцам	Нэг алцам, алхаа, алхам (1метр) (Пүрэвжанцан, 1998:2)
Нүд: гүйлгэх бараалах	一眨眼 нүд ирмэхийн зурах цаг 转眼间 нүдээ гүйлгэх цаг	Нүд гүйлгэх зуур Барааны газар (холын буюу 1020 км доторх зай)
Чих: сонор	耳听八方 (惠红军, 2024:87) найман зүгийг чагнах - сонор соргогийг зүйрлэсэн хэллэг	Сонорт хүргэх (ямар нэгэн зүйлийн тухай бусдад дуулгах)


Уртын хэмжээг хүний биеэр хэмжүүр болгон монгол, хятад хэлэнд хэмжих зуршил бас байдаг. Монгол хэлэнд нэг хуруу (1-2см), хоёр хуруу; ямх(3.5см), мухар сөөм (14см), үзүүр сөөм (18см орчим), мухар төө (18-20см), үзүүр төө (20-22см), мухар тохой (32-54см), үзүүр тохой (40-42см), дэлэм (1м), алд (1.6-1.8м) (Пүрэвжанцан, 1998: 40-41) зэрэг хэмжүүр үг байдаг.

Хятад хэлэнд 一寸(уї сцн) эсвэл一指 (1-2см) = нэг хуруу, 一寸半 (уї сцн ban) = хоёр хуруу, 三寸 (sān сцн) = дөрвөн хуруу, 拃 (zhǎ) = үзүүр төө, 掌 (zhǎng) = алга (8-10см), 肘 (zhǒu) = үзүүр тохой, 庹 (tuō) = алд зэрэг хэмжүүр үг байдаг. Тухайлбал:


Хүснэгт 2. Монгол, хятад хэлний хэмжих илэрхийллийн адил тал

Монгол хэл	Хятад хэл
Нэг хуруу	一寸(уї сцн) эсвэл一指(1-2см)
Хоёр хуруу	一寸半 (уї сцн ban)
Дөрвөн хуруу	三寸 (sān сцн)
Алга	掌 (zhǎng) (8-10см)
Үзүүр төө	拃 (zhǎ)
Үзүүр тохой	肘 (zhǒu)
Алд	庹 (tuō)

Тайлбар: Монгол, хятад хэлний хэмжих илэрхийллийн адил талыг зөвхөн гараар хэмжих арга дээр тулгуурлан гаргасан юм.



Зураг 1. Монгол хэмжих арга



Зураг 2. Хятад хэмжих арга

4.3. Үйлийн хэмжүүр үгийн харьцуулалт

“Хэмжүүр”-ийг тоолж болох боловч бодгаль бие болгон тоолох шаардлагагүй, эсвэл бодгаль биеэр тоолоход хүндрэлтэй байгаа үед монгол, хятад хэлний хэмжүүр үгийн илэрхийлэх арга нь адил, бүгд үйлийн хэмжүүр үгээр хэдэн удаа гэдэг үйлийн давтамжийг илэрхийлдэг. Тухайлбал:

Хятад хэл

读了两遍
看了两次
叫了三回
去了一趟

Монгол хэл

- Хоёронтоо уншив
- Хоёронтоо үзэв
- Гурвантаа дуудав
- Нэгэнтээ очив

Дээрх жишээнүүдээс үзвэл, хятад хэлний “遍、次、回、趟” зэрэг **үйлийн хэмжүүр үг** (动量词) нь монгол хэлний “тоо+таа” гэх үйлийн давтамж тохирч байгааг мэдэж болно. Энэ нь монгол хэлний үйлийн хэмжүүр үг нь хятад хэлний үйлийн хэмжүүр үгээс хамаагүй бага байгааг харуулж байна.

Үүнээс гадна, монгол хэлэнд үйлийн хэмжүүр үгээр илтгэх шаардлагагүй байдал ихэвчлэн гардаг. Тухайлбал,

Хятад хэл

看了一眼 (нүд)
打了一拳 (нударга)
踢了一脚 (хөл)

Монгол хэл

- Нэг харсан
- Нэг цохисон
- Нэг өшиглөсөн

Эдгээр жишээнд монгол хэлний хэсэгт заавал “нэг” гэх тооны үгийг өмнө нь тавих шаардлагагүйгээр шууд “харсан, цохисон, өшиглөсөн” гээд хэлсэн ч болно. Энэ нь монгол хэлний үйлийн хэмжүүр үг нь хятад хэлнийхээс тоогоор бага боловч энэ нь монгол хэлний үйл үгийн хувилал, залгамал хэлний онцлог

бүрэн хөгжсөнийг дам илэрхийлж байна. Жишээлбэл, монгол хэлэнд үйл үгийн хувилал (төгсгөл, цаг, баймж, захирах хэв гэх мэт) маш нарийн бөгөөд энэ нь үйлдлийн утгыг илэрхийлэхэд хангалттай байдаг тул хэмжүүр үг шаардлагагүй тохиолдол их байдаг. Харин хятад хэлэнд үйл үгийн хувилал харьцангуй бага тул үйлдлийн цар хүрээ, давтамж зэргийг илэрхийлэхийн тулд хэмжүүр үг зайлшгүй хэрэглэгддэг. Иймээс монгол хэлний үйлийн хэмжүүр үг цөөн байгаа нь түүний хэлзүйн бүтцийн онцлогийг харуулж байгаа хэрэг юм.

4.4. Жинхэнэ нэрийн хэл зүйн шинжийн харьцуулалт

Монгол, хятад хэлний бүх жинхэнэ нэр хэл зүйн шинжээрээ ерөнхий ганц ба олон тоо заах зүй тогтолтой боловч учир зүйгээс шалтгаалж хэл ярианд ихэнх нь ганц ба олон тооны аль алинд, зарим нь зөвхөн ганц тоонд, үлдсэн хэсэг нь зөвхөн олон тоонд хэрэглэгдэхээс гадна олны утгатай боловч хам бүтцээс шалтгаалж олон тооны нөхцөлөөр хэлбэрждэггүй тохиолдол ч байдаг. Жишээ нь:

Монгол хэл

Ширээн дээр **ном** байна.

Миний **гэрээр** зочлоорой.

Танд **цэцэг** бэлгэлье.

Хятад хэл

- 桌上有**书**。

- 做客到我**家**吧。

- 给您送**花**。

Монгол, хятад хэлэнд “ном (书), гэр (家), байшин (房子), цэцэг (花), гол нуур (河,湖), уул (山)...” гэх мэт тоо ширхгээр тоолж болох бодит юмсыг заасан нэр үгс ерөнхий ганц ба олон тоог ялгаж заана. Хятад хэлэнд ч адил.

Монгол хэл

Нэгэн **сэтгэл**

Нэг **ухаанаар**

Хятад хэл

- 一份**心意**

- 一种**智慧**

- Монгол хэлэнд “сэтгэл, ухамсар, зориг, чадал, хүсэл, мөрөөдөл, ухаан” гэх мэт хийсвэр ухагдахуун заасан нэрсийг тоолж болшгүй байж, ихэвчлэн ерөнхий ганц тоог заана. Гэвч, хятад хэлэнд “ухамсар (自觉), зориг (信心), чадал (力量), хүсэл, мөрөөдөл (梦想), ухаан (智慧)” зэрэг хийсвэр нэрсийг хэмжүүр үг “份, 种” (зүйл, төрөл) ашиглан “一份心意” (нэгэн сэтгэл), “一种智慧” (нэг ухаанаар) гэсэн санааг илэрхийлж болдог.
- Үүнээс гадна, монгол, хятад хэлэнд цас бороо, элс, хайрга, шороо гэх мэт ширхгээр нь тоолж болшгүй юмсыг заасан нэрс ихэвчлэн ерөнхий ганц тоог заана.
- Монгол хэлэнд “Хөх хот, Улаанбаатар, Эрдэнэт” гэх мэт оноосон нэрс, “нүд, чих, хөл, гар, гутал, бээлий” гэх мэт хос юмны нэрс, нар, сар, дэлхий, алтан гадас гэх мэт ертөнцөд цорын ганц байх юмсын нэрс ганц тоог заана. Хятад хэлэнд ч адил北京Бээжин, 上海Шанхай, 眼睛нүд, 耳朵чих, 手гар, 脚хөл, 靴子гутал, 手套бээлий гэх мэт.

- Монгол хэлэнд “Архангайнхан, хөдөөгийнхөн” гэх мэт хураасан олныг заасан жинхэнэ нэрс олон тооны нөхцөлөөр хувилахгүйгээр олныг зааж болно. Хятад хэлэнд бол задлаг аргаар “北京人 бээжингийн хүн, 上海人 шанхайн хүн, 富人 баян хүн, 公务员 төрийн албан хаагч” хэмээн олныг заана.
- Монгол хэлэнд “Олон хүн, цөөн дэвтэр, хэдэн үзэг, зарим сурагч, багц зүү, толгой ёотон, боодол цай, арваад ном, хориод ширээ” гэх мэтчилэн өмнөө ерөнхий олныг заасан болон тодорхой тоо заасан тодотголтой жинхэнэ нэр олон тооны нөхцөлгүй хэрэглэгдэнэ. Харин хятад хэлэнд задлаг аргаар “很多人 олон хүн, 少量本子 цөөн дэвтэр, 有些学生 зарим сурагч, 一包针 багц зүү, 一包茶 боодол цай, 十来本书 арваад ном, 二十多个桌子 хориод ширээ, 三块糖 гурван хэсэг чихэр” гэх мэтчилэн задлаг аргаар ерөнхий олон болон тодорхой олон тоог заана.
- Монгол хэлэнд “Өндөр өндөр уул, намхан намхан байшин, зузаан зузаан ном” гэх мэт тодотгосон үгийг нь давтаж салангид олны санааг заасан тохиолдолд жинхэнэ нэрийг олон тооны нөхцөлөөр хувилгах хэрэгцээгүй байдаг. Хятад хэлэнд ч адил “高高的山” Өндөр өндөр уул, “白白的雪” цав цагаан цас, “矮矮的树” намхан намхан мод, “厚厚的书” зузаан зузаан ном гэх мэтчилэн тодотгосон үгийг нь давтаж салангид олны санааг заасан тохиолдол байдаг.

5. Дүгнэлт

Монгол, хятад хэлний хэмжүүр үгийн илэрхийлэх арга, бүтцийн шинжийг зэрэгцүүлэн үзвэл, хоёр хэлний төстэй тал, ялгаатай тал, өвөрмөц онцлогоороо тодорхой .

Нэгд, хэмжээ илэрхийлэх аргын хувьд хятад хэлний тооны үг ерөнхийдөө нэр үгтэй шууд хослуулах боломжгүй, дунд нь хэмжүүр үгийг заавал хэрэглэдэг. Монгол хэлний хувьд тооны үг + нэр үгийн хослол буюу дунд нь хэмжүүр үгийг нэмж хэрэглэх гэсэн хоёр тохиолдол байдаг. Хятад хэлэнд үйлийн хэмжүүр үг олон байгаа нь хятад хэлний тоо хэмжээ илэрхийлэх аргын хувьд задлаг арга ба үг давтах аргыг хэрэглэдэг бол, монгол хэл нь нийлэг аргаараа онцлогддог тул үйлийн хэмжүүр үг харьцангуй цөөн байдаг.

Хоёрт, хятад хэлний тооны үг, нэр үгийн хослолын бүтэц нь ерөнхийдөө “тооны үг + хэмжүүр үг + нэр үг” байдаг бол монгол хэлний бүтэц нь “тооны үг + хэмжүүр үг + нэр үг” ба “тооны үг + нэр үг” гэсэн хоёр төрөл байдаг. Монгол хэлний үйлийн хэмжүүр үгийн илэрхийлэх арга нь “тооны үг + хэмжүүр үг + үйл үг” хэлбэр бол, хятад хэлний үйлийн хэмжүүр үгийн илэрхийлэх бүтэц нь “үйл үг + тооны үг + хэмжүүр үг” хэлбэрээр илэрдэг байна.

Гуравт, хоёр хэлний хэмжүүр үгийн өвөрмөц онцлогийн хувьд, монгол хүн нь ертөнцийн юмс үзэгдлийг “биед суурилан” хэмждэг бол хятад хүн биед суурилахаас гадна, ихэвчлэн “дүрсэд” суурилан хэмжих нь олон байдаг. Жишээ нь “一枝树枝” Нэг модны мөчир, “一片叶子” Нэг навч гэдэгт “枝” ба “片” нь модны мөчрийн дүрсэд суурилан “木” мод гэх үг + “支” салаа, салбар гэсэн утга

бүхий хоёр ханз нийлж модны мөчрийг хэмжин нэрлэсэн байна. “片” гэдэг нь зүсмэл, хавтгай зүйлийг хэмжин нэрлэхэд хэрэглэдэг. Монгол хэлний хэмжүүр үг нь монгол ахуй амьдрал, нүүдлийн соёлоос шалтгаалан хүний таван сэрлийн эрхтэн, нүүж суух зан дадалтай нь шууд холбоотой байдаг. Энэ нь монгол хүний юмны тоо хэмжээг харахад төрөл нь юу байхыг илүү чухалчилдаг зүй тогтлыг харуулж байна. Харин хятад хэлний хэмжүүр үг нь хятадын тариалангийн соёл, ахуй амьдралаас нь шалтгаалан юмны тоо хэмжээг нарийн тоолж хэмжих зан дадалтайг харуулж байна.

Ерөнхийлбөл, янз бүрийн хэлэнд хэмжүүр үгийн үүрэг ялгаатай байдгийг монгол, хятад хэлний жишээнээс маш тод харж болно. Монгол хэлэнд тоог заасан утга гарч ирнэ. Гэвч тоо хэмжээг жинхэнэ утгаар нь хэрэглээгүй тохиолдолд хэмжүүр үг хэрэглээгүй байж болно. Харин хятад хэлэнд орхигдуулж болохгүй, үйлийн хэмжүүрийг заахдаа хоёр хэл адил төстэй мэт боловч, монгол хэлний үйл үг баялаг тул хэл зүйн аргаар илэрхийлж болно. Харин зарим хэлэнд бодит ертөнцийн юмсыг хэлбэр дүрс, хэмжээ байдлаар нь тухайн нэр үг илэрхийлэн байдаг зүйлийг ангилж хуваасан утгыг илэрхийлнэ. Иймээс, тус хоёр хэлийг судлах хүмүүст авч хэлбэл, эдгээр ялгаа, зөрөө, онцлогийг ялган байж судлах хэлнийхээ төвшнийг улам сайжруулахад тус дэм болно.

Ном зүй

А. Монгол хэлээр:

- Бат-Ирээдүй, Ж.** (2010). *Монгол хэлний тооны болон хэмт үгийн сан*. Улаанбаатар:Мон-Эдюкэш н пресс. [Bat-Ireedui, J. *Mongol helmii toony bolon khemt ügiin san* [The Vocabulary of Quantitative and Qualitative Words in Mongolian Language]. Ulaanbaatar: Mon-Edyukeishn press. 2010]
- Гонгоржав, Г.** (1992). *Монголчуудын эрдэм ухааны уламжлал*. Улаанбаатар. [Gongorjav, G. *Mongolchuudyn erdem ukhaany ulamjalal*. [Mongolian Scholarly Tradition]. Ulaan- baatar. 1992]
- Пүрэвжанцан, А.** (1998). *Монголчуудын хэмжээ илэрхийллийн товч тайлбар толь*. Улаанбаатар. [Pürevjantsan, A. *Mongolchuudyn khemjee ilerghiiliin товч tailbar toli*. [Concise Dictionary of Mongolian Measurement Expressions]. Ulaanbaatar. 1998]
- Пүрэвжанцан, А.** (2017). *Монголчуудын хэмжээ илэрхийлэл*. Улаанбаатар. [Pürevjantsan, A. *Mongolchuudyn khemjee ilerghiilel*. Ulaanbaatar. 2017]
- Пүрэвжанцан, А.** (2022). Монголчуудын аж төрөх ёсны хэмжигдэхүүнийг илэрхийлэх байдал. *Монгол судлал*. 45(572), 32–34. [Pürevjantsan, A. Mongolchuudyn aj törökh yosny khemzhigdekhüüniig ilerghiilekh baidal. *Mongolian Studies*. 45(572), 32–34. 2022]

Пүрэв-Очир, Б. (2007). *Монгол хэлний бүтэц, утга, үүрэг, хэрэглээ*. Улаанбаатар: Мөнхийн үсэг. [Purev-Ochir, B. *Mongol khelnii бүтэц, утга, үүрэг, хэрэглээ*. Ulaanbaatar: Monkhiin üseg. 2007]

Ринчен, Б. (1969). *Монгол Ард Улсын хамниган аялгуу*. Улаанбаатар: Шинжлэх ухааны академи. [Rinchen, B. *Mongol Ard Ulsyn hamnigan ayalguu*. [The Hamnigan Dialect of the Mongolian People's Republic]. Ulaanbaatar: Shinjlekh uhaany akademi. 1969]

Shanjimituo. (2022). *Монгол оюутнуудын хятад хэл суралцах явцад суурилсан монгол, хятад хэлний нэгж хэмжүүр үгийн харьцуулсан судалгаа. гадаад хэлний боловсролын магистрын зэрэг горилсон бүтээл. 7.* [Shanjimituo. *Mongol oyutnuudyn khyatad khel suraltsakh yavtsad suurilsan mongol, khyatad khelnii negj khemjüür ügiin kharitsuulsan sudalгаа*. [A Comparative Study of Mongolian and Chinese Unit Measurement Words Based on Mongolian Students' Chinese Language Learning Process] master's degree dissertation. 7. 2022]

Хай инхуа. Насан-урт. (2009). Монгол хэлний дүрмийн мэдээллийн толь бичгийн хэмжүүр үгийн мэдээллийн хөмрөг байгуулах. *ӨМӨЗО-ны багшийн их сургуулийн сэтгүүл* 1: 71-72. [Hai inhua., Nasan-urt. Mongol khelnii дүрмийн мэдээллийн толь бичгийн хэмжүүр үгийн мэдээллийн хөмрөг байгуулах. *ӨМӨЗО-ны багшийн их сургуулийн сэтгүүл* 1: 71-72. 2009]

Б. Хятад хэлээр:

杰, 何. (2008). 现代汉语量词研究. 北京:北京语言大学出版社. jié, hé. *Орчин үеийн хятад хэлний хэмжүүр үгийн судалгаа*. Бээжин: Бээжингийн хэлний их сургуулийн хэвлэлийн хороо. [jié, hé. *Orchin üyeiin khyatad khelnii khemjüür ügiin sudalгаа*. [A Study of Modern Chinese Quantifiers]. Beijing: Press Committee of Beijing Language and Culture University. 2008]

红军, 惠. (2024). 汉语数词的认知类型研究. 北京: 中国社会科学. hóng jūn, huì. *Хятад хэлний хэмжүүр үгийн танин мэдэхүйн судалгаа*. Бээжин: Хятадын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэн. [hóng jūn, huì. *Khyatad khelnii khemjüür ügiin tanin medekhiin sudalгаа*. [A Study on the Cognitive Types of Chinese Numerals]. Beijing, Chinese Academy of Social Sciences. 2024]

汝建,孙. (2003). 现代汉语. 南京:南京大学出版社. rǔ jiàn , sūn. *Орчин үеийн хятад хэл*. Нанжин: Нанжингийн их сургуулийн хэвлэлийн хороо. [rǔ jiàn , sūn. *Orchin üyeiin khyatad khel*. [Modern Chinese] Nanjing University Press. 2003]